

Д/д	Оролцогчийн тодруулга	Захиалагчийн хариулт
1	Тендерийн баримт бичгийг орчуулах, материалыг баталгаажуулах болон банкны баталгаа гаргах зэрэгт нэлээд хугацаа хэрэг болдог тул бид тендерийн баримт бичиг хүргүүлэх хугацааг 2024 оны 06 сарын 10-ны өдөр хүртэл хойшлуулах хүсэлт гаргаж байна. Зөвшөөрнө үү.	Захиалагчийн зүгээс оролцогчдын гаргасан хүсэлт, шаардлагыг үндэслэн тендер хүлээн авах эцсийн хугацааг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл хугацааг сунгасан. Дахин сунгахгүй.
2	Тендерийн бичиг баримтыг боловсруулан Монгол хэл рүү орчуулах, гадаадад үйлдсэн баримт бичгийг апостиль гэрчилгээгээр баталгаажуулах, тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтыг бэлтгэх, хянах болон Банкны Баталгаа гаргуулах зэрэгт тодорхой хугацаа шаардлагатай байгаа тул тендерийн материал хүлээн авах хугацааг 2024 оны 6 сарын 12 хүртэл сунгаж өгнө үү.	
3	Тендерийн хугацааг 6 сарын 10 хүртэл сунгах боломжтой юу? Тендерийн бичиг баримтыг боловсруулан Монгол хэл рүү орчуулах, гадаадад үйлдсэн баримт бичгийг апостиль гэрчилгээгээр баталгаажуулах, тендерийн техникийн тодорхойлолтыг хянаж бэлтгэх зэрэгт тодорхой хугацаа шаардлагатай байгаа тул тендерийн материал хүлээн авах хугацааг сунгаж өгнө үү. Хавсралтаар консорцумын гэрээгээр оролцох талуудын албан хүсэлтийг илгээлээ.	
4	Танай хотоос зарласан FIDIC мэргэшсэн байх нөхцөл нь “FIDIC сургалтад суусан батламж” (Certificate of Participation) байх эсвэл мэргэшсэн гэрчилгээ (Certificate of Professional) байх эсэхийг дахин нэг тодорхой хариулж өгнө үү. Холбогдох гэрчилгээ, батламж жишээ (Sample)-г худалдан авах ажиллагааны систем дээр тодорхой шуурхай оруулж өгөхийг хүсье.	FIDIC-ээр мэргэшсэн байх нөхцөл нь мэргэшсэн гэрчилгээ (Certificate of Professional)-ээр нотлогдоно. “FIDIC сургалтад суусан батламж” (Certificate of Participation) авсан байх нь FIDIC-ээр мэргэшсэн байх нөхцөлийг хангахгүй. FIDIC гэрээгээр мэргэшсэнийг олон улсын инженерүүдийн холбоо FIDIC-ээс батламжилсан сургалтын байгууллагуудаас олгодог болно. Гэрчилгээ, батламжийн жишээг системд оруулах боломжгүй.